



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/486

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны "Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай" XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Алтаргана 2024" олон улсын XV их наадмын шоу арга хэмжээ, соёл урлагийн чиглэлээр зохион байгуулагдах 8 төрлийн тэмцээн уралдааны тайз, карказ, гэрэлтүүлэг, чимэглэл материалын түрээсийн зардал болон гүйцэтгэгч байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад заагдсан гүйцэтгэгч байгууллагуудтай холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулах эрхийг Соёл, урлагийн газрын дарга (Г.Алдармөнх)-д олгосугай.

3. Гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

4. Дээрх хөрөнгийг хавсралтаар баталж, орон нутгийн хөгжлийн сангийн "Алтаргана 2024" арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010631

07 дүгээр сарын 02-ны өдрийн 1/486 дугаар
Аймгийн Засаг даргын 2024 оны
захирамжийн хавсралт

ТҮРЭЭСИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Компанийн нэр	Үнийн дүн	Эзэмшигчийн овог нэр	Данс	Байршил
1	“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын оройн шоу арга хэмжээний гэрэл, гэрэлтүүлэг түрээс	“Төв гэрэл” ХХК	16,445,000	Ойдовын Цагаанхүү	Төрийн банк 310000364944	Төв аймаг Зуунмод сум 1-р баг 27-20 тоот
2	“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын оройн шоу арга хэмжээний тайз, карказ түрээс	“PIAIR” ХХК	18,084,000	Ц.Гантөмөр	Хаан банк 5756163367	Төв аймаг Зуунмод сум Манзушир өргөө хороолол 1-р байр К блок 5 тоот
3	“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын оройн шоу арга хэмжээний лед дэлгэц түрээс	“Хүчит аргун” ХХК	19,580,000	Цагаанхүүгийн Төмөр-Очир	Худалдаа хөгжлийн банк 458047463	Баянгөл дүүрэг 4-р хороо Эрдэнэ суварга ХХК-н байр 404 тоот
4	“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын оройн шоу арга хэмжээний тайзны чимэглэл, материалын түрээс	“Эйч Жи Эм” ХХК	6,886,000	Энхболорын Ганхуяг	Хас банк 5000522567	Төв аймаг Зуунмод сум МАН-н байр
5	“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын оройн шоу арга хэмжээний хөгжим, техник	“Түшиг дуу хоолой” ХХК	11,000,000	Э. Солонго	Худалдаа хөгжлийн банк 466024678	Орхон аймаг Баян-Өндөр сум Согоот

	тоног төхөөрөмж түрээс					баг 6-9-6 тоот
6	“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын “Дангина” гоо бүсгүй шалгаруулах тэмцээнд хэрэглэгдэх тайз, карказ, дэлгэц, хөгжим техник хэрэгсэл, гэрэлтүүлэг	“Эм Өү Ти Оргил” ХХК	19,800,000	А.Мөнгөншагай	Голомт банк 1205188916	БЗД-ын 2р хороо 1-165
Нийт дүн					91,795,000	